



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/190

Хэрлэн сум

Хоёр гэрийг засч сэлбэхэд зориулж
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар шинэчлэн батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Шуурхай штабын 2022 оныдугаар хуралдаанаар шийдвэрлэсний дагуу коронавируст цар тахлын онцгой байдлын үед өрхийн эмнэлгүүдийн ачаалал, дарааллыг бууруулах зорилгоор ашигласан Засаг даргын Тамгын газрын баяр ёслол, хүндэтгэл хүлээн авалтын хоёр гэрийг засч сэлбэхэд 3 527 000 (гурван сая таван зуун хорин долоон мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
04 дугаар сарын 12-ны өдрийн
А/190 захирамжийн хавсралт

6 ханатай гэрийн засварын үнийн судалгаа

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Үнэ	Нийт үнэ
1	6 ханатын бүрээс	ш	2	130000	260000
2	Цаваг	ш	2	100000	200000
3	Гэрийн бүслүүр	м	180	800	144000
4	хаяавч	ш	2	70000	140000
5	Тооно гялгар	м	7	20000	140000
6	Модны цавуу	ш	3	12000	36000
7	Лак	л	10	19500	195000
8	Багс	ш	4	3000	12000
9	Хулдаас	м	40	15000	600000
10	Шрүп	ш	4	5000	20000
11	Углаа перцэнт	ш	2	650000	1300000
12	Өрх	ш	2	90000	180000
13	Унь	ш	10	30000	300000
НИЙТ ДҮН					3527000